



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Аудитын сэдэв: Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Аудитын код: ДГА-2025/06-08-ШТА-НА

Цахим хуудас:
www.audit.mn
Сайншанд сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziiit@audit.gov.mn

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор:

Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитор:

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

М.Оюу-Эрдэнэ

Цахим хаяг: oyu-erdenem@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 4/19

Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 10.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, 2021 оны А/69, А/71 дугаар тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын заавар, аргачлал", "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал", 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаартай тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх хэсэг, 2024 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай" тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитаар тогтоосон албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3.Аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газарт тус тус хүргүүлсүгэй.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т үүрэг болгосугай.



Т.ГАН-ӨЛЗИЙ

010319079

АГУУЛГА:

Тайлан баталгаажуулах тушаал	1
Товьёг	2
Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4-5

БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг МУ-ын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2021-2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрт ерөнхий утгаар нийцүүлэн тусгасан байна.....	6
1.2. УТХО-ыг иргэдийн санал, ЭЗ-ийн үр ашиг, нийгмийн ач холбогдолд үндэслэн тооцох төлөвлөлтийн шалгуур бүрэн хангагдахгүй байна.....	6-7
1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй ТАХ-г хэрэгжүүлсэн байна.....	7-9
1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр орон нутгийн өмчлөлд шилжих, боломжтой ТАХ-г төлөвлөж хэрэгжүүлсэн байна.....	9

БҮЛЭГ 2. Төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зарлах, тендерийг үнэлэх үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэх шаардлагатай байна.

2.1. Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.....	9-12
2.2. Зарим ТАХ-ны худалдан авах ажиллагааны тендер зарлагдсанаас хойш хугацаанд зураг, төсвийг магадлалаар баталгаажуулсан байна.....	11-12
2.3. Зарим тендерийг холбогдох хууль, журмын дагуу үнэлээгүйгээс 4 тендер шалгаруулалт цуцлагдсан байна.	12-13

БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь хүлээн авсан хэдий ч зарим ажил зураг, төсвийн дагуу хийгдээгүй, ашиглагч байгууллагын НББ-д бүртгээгүй байна.

3.1. Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих ТАХ-ний санхүүжих дүнг Төсвийн тухай хуульд бүрэн тусгасан ч, үнийн өсөлтийн зөрүүний нэмэлт санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгаж баталсан байна.....	13-16
3.2. УТХО-аар хэрэгжүүлсэн 5 ТАХ-ний гэрээг холбогдох хууль, журмын шаардлагад үндэслэхгүйгээр сунгасан байна.....	16-18
3.3. Зураг, төсвийн дагуу хийгдээгүй, бүрэн хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.....	18-21
3.4. Бүрэн хэрэгжиж дууссан 6,980.1 сая төгрөгийн өртөгтэй, 4 ТАХ-г ашиглагч байгууллагын НББ-д тусгаагүй байна.....	21-22

Дүгнэлт:	23
Зөвлөмж:	24-25
Тайлангийн төсөлд ирүүлсэн санал:	26-29

Хүснэгтийн товъёг:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ТАХ-ний төсөвлөлтийн шаардлага хангасан тухай мэдээлэл	9
Хүснэгт 2	Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн шийдвэр	11
Хүснэгт 3	Худалдан авах ажиллагааны арга сонгосон мэдээлэл	12
Хүснэгт 4	ТАХ-ний зураг, төсөвт магадлалын дүгнэлт гаргуулсан судалгаа	13
Хүснэгт 5	Сангийн яамнаас хүчингүй болгосон тендерийн жагсаалт	14
Хүснэгт 6	УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний эх үүсвэр, тайлант оны гүйцэтгэл	16
Хүснэгт 7	УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-д олгосон санхүүжилт	17
Хүснэгт 8	ТАХ-ний гүйцэтгэлийн харьцуулалт /2024.12 сар/	17
Хүснэгт 9	Гэрээний хэрэгжилт	18

Зургийн товъёг:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем	7
Зураг 2	УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний санал авах тухай мэдээлэл хүргэсэн байдал	7
Зураг 3	Саран хөхөө театрын барилга /нүүрэн тал/	19
Зураг 4	Саран хөхөө театрын барилга /ар тал/	19
Зураг 5	Сайншанд сумын “50 ортой төрөх эмнэлэг”-ийн барилга	19
Зураг 6	Замын-Үүд сумын “Соёл спортын цогцолбор	20
Зураг 7	Замын-Үүд сумын хуучин 80 м³ усан сан	21
Зураг 8	Замын-Үүд сумын төвийн 2.15 км авто замын шинэчлэл хийх ажил	21
Зураг 9	Сайншанд, Замын-үүд сумын ЕБС-ийн сурагчдын хэрэгцээнд автобус худалдан авах ажлын	24

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
АНТАГ	Аймаг, нийслэлийн төрийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ОНТАГ	Орон нутаг дахь Төрийн аудитын газар
ЭЗ	Эдийн засаг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УХО	Улсын хөрөнгө оруулалт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТХО	Төсвийн хөрөнгө оруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЭЗХЯ	Эдийн засаг хөгжлийн яам
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
СоС	Соёлын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ХАА	Худалдан авах ажиллагаа
УТ	Улсын төсөв
УКД	Улсын комиссын дугаар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
БХТ	Барилгын хөгжлийн төв
АТГ	Авлигатай тэмцэх газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
МУИХ	Монгол улсын Их хурал
УОНТХО	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитыг хийсэн.

Аудитын зорилго.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг УИХ болон Үндэсний аудитын газар, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Тус зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагч, харьяа байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагчид, аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ, ХААГ, бусад хамрагдагч байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817- 1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817- 8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашигласан.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлэн, ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Б.Ариунбаатар, М.Оюу-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг МУ-ын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2021-2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрт ерөнхий утгаар нийцүүлэн тусгасан байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Дорноговь аймагт нийт 113,542.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүжүүлэхээр батлагдсан. Үүнээс тайлант онд 67,994.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 12 ТАХ-ний эрхийг орон нутагт шилжүүлсэн байна.

Дорноговь аймагт УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан нийт төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутагт хэрэгжүүлэх “Дорноговь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт ерөнхий агуулгаар бүрэн тусгагдсан байна.

1.2. УТХО-ыг иргэдийн санал, ЭЗ-ийн үр ашиг, нийгмийн ач холбогдолд үндэслэн тооцох төлөвлөлтийн шаардлага бүрэн хангагдаагүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд журамд тусгагдсан агуулгыг ерөнхий байдлаар мэдээлсэн ба аймгийн Засаг даргын харьяа агентлаг байгууллагууд, сумдын ЗДТГ нь төлөвлөлттэй холбоотой санхүү, эдийн засгийн шинжилгээг тодорхой тооцоогүй, төсөлтэй холбоотой бусад шийдвэр мэдээллийг бүрэн мэдээлээгүй, мөн санал өгсөн иргэдийн тоо цөөн байгаа нь иргэдийн саналыг үнэлж эрэмбэлсэн байдал төлөвлөлтийн үр дүнг дүгнэх боломжгүй, системээс төлөвлөлттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл авах боломж бүрдээгүй байгаа нь УТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төсөвт өртгийг дэлгэрэнгүй тооцоолоогүй, ТАХ-г үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг журам, аргачлалын дагуу хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн зорилт бүрэн хангагдаагүй байна.

1.3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар УТХО-аар Дорноговь аймагт хэрэгжүүлэх 113,542.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ батлагдсан байна.

ТЕЗ-ийн төсвийн төсөл хүргүүлснээс хойш хугацаанд техникийн нөхцөл олгогдсон 4, зураг төсөв хийгдсэн 7, магадлалын дүгнэлт гарсан 8 ТАХ-г төлөвлөлтөд тусгаж батлуулсан байна. /Хүснэгт№1/

Төлөвлөлтийн шаардлага хангасан байдал

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Магадлалын ерөнхий дүгнэлтийн огноо	Зураг, төсөв боловсруулсан огноо	Техникийн нөхцөл олгосон огноо			
				Цахилгаан хангамж	Дулаан хангамж	Ус хангамж, ариутгах татуурга	Холбоо дохиолол
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга /Дорноговь, Сайншанд сум/	2024.08.19	2023.09.01	-	2023.10.03	2023.10.03	2023.11.06
2	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорноговь, Сайншанд сум/	2024.04.09	-	-	-	-	-
3	Сумын төвийн авто замын шинэчлэл, 2.15 км /Дорноговь, Замын-Үүд сум/	2024.03.14	2024.03.07	-	-	-	-
4	Соёлын төвийн барилга /Дорноговь, Дэлгэрэх сум/	2024.05.31	2023.09.15	2023.11.10	2023.10.12	2023.10.12	-

5	Ундны усны 3000 м3 багтаамжтай усан сан /Дорноговь, Замын-Үүд сум/	2024.02.23	2023.09.01	-	-	-	-
6	Дорноговь аймгийн дулааны станцын өргөтгөл /Дорноговь, Сайншанд сум/	2023.07.17	2023.07.17	-	-	-	-
7	Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Дорноговь, Сайншанд сум/ Багц 1	2024.07.18	2024.04.15	2024.03.18	-	-	-
8	Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Дорноговь, Сайншанд сум/ Багц 2	2024.07.18	2024.04.15	2024.03.18	-	-	-

Аймгийн Засаг дарга МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний нэгжийн тухай хууль, бусад журамд заасан эрх, үүргийн дагуу аймаг орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай байгаа ТАХ-ний саналыг ард иргэдээс авч, холбогдох байгууллагуудад саналыг уламжлах, батлуулах чиг үүргийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулсан байгаа ч ТЕЗ-ийн харьяа болон эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас ТАХ-ний ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, бусад зардлын дэлгэрэнгүй тооцоолол, судалгаа хийгээгүй, ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулагдаагүй зэрэг хууль, журамд заасан шаардлага хангаагүй ТАХ-г хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгуулах санал ирүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ны жагсаалтыг улс, орон нутгийн бодлогын баримт бичигтэй уялдуулан хэрэгцээ шаардлагаар эрэмбэлж, хуулийн шаардлагад нийцсэн ажлыг тусгах, ирүүлээгүй тохиолдолд хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тусгахгүй байх зарчмыг баримталж төлөвлөөгүйгээс ТАХ-г хэрэгжүүлэх явцад ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орох, төсөвт өртөг нэмэгдэх, төсвийн ачааллыг нэмэгдүүлэх нөхцөл үүссэн байна.

1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр орон нутгийн өмчлөлд шилжих, боломжтой ТАХ-г төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Сайдын багцаас эрх шилжүүлэн шинээр хэрэгжүүлсэн нийт 49,836.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтад заасан, орон нутгийн өмчлөлд шилжих боломжтой ТАХ байна.

2. Төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зарлах, тендерийг үнэлэх үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэх шаардлагатай байна.

2.1. Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, тендер шалгаруулалтын аргыг худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Дорноговь аймагт нийт 113,542.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т заасны дагуу холбогдох сайдаас аймгийн Засаг даргад 67,994.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 12 ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. /Хүснэгт №2/

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн шийдвэр

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Эрх шилжүүлсэн шийдвэр
1	БШУС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга /Дорноговь, Сайншанд сум/	2024	2025	25,101.6	7,530.5	БШУС-ын 2023.12.05 А/550
2	БШУС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорноговь, Сайншанд сум/	2024	2025	3,321.2	1,660.6	БШУС-ын 2023.12.05 А/550
3	БШУС	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын автобус /Дорноговь, Сайншанд, Замын-Үүд сум/	2024	2024	1,000.0	1,000.0	БШУС-ын 2023.12.05 А/550

4	ЗТХС	Сумын төвийн авто замын шинэчлэл, 2.15 км /Дорноговь, Замын-Үүд сум/	2024	2025	4,755.7	1,000.0	ЗТХС-ын 2024.02.26 А/43
5	ССАЖЗС	Саран хөхөө театрын барилга, 700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/	2021	2024	18,503.1	7,033.8	ЗГ-ын 2021.01.20 15 тогтоол
6	ССАЖЗС	Соёлын төвийн барилга /Дорноговь, Дэлгэрэх сум/	2024	2025	4,191.9	1,257.6	Соёлын Сайдын 2021.03.04 А/76
7	ХББОСС	Ундны усны 3000 м3 багтаамжтай усан сан /Дорноговь, Замын-Үүд сум/	2024	2025	2,000.0	1,000.0	БХБС-ын 2024.02.29 42
8	ХХААХҮС	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Дорноговь/	2024	2025	1,800.0	1,800.0	ХХААХҮС-ын 2024.01.11 А/14
9	ЭХС	Дорноговь аймгийн дулааны станцын өргөтгөл /Дорноговь, Сайншанд сум/	2024	2025	5,999.8	2,999.9	ЭХС-ын 2024.01.31 А/48
10	ЭХС	Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Дорноговь, Сайншанд сум/ Багц 1	2024	2024	508.0	508.0	ЭХС-ын 2024.01.31 А/48
11	ЭХС	Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Дорноговь, Сайншанд сум/ Багц 2	2024	2024	313.9	313.9	ЭХС-ын 2024.01.31 А/48
12	ЭМС	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Дорноговь, Замын-Үүд сум/	2024	2024	499.3	499.3	ЭМС-ын 2024.01.09 А/12
Нийт дүн					67,994.5	26,603.5	

Тайлант онд эрх шилжиж хэрэгжсэн 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

2.2. Зарим ТАХ-ны тендер шалгаруулалт зарлагдсанаас хойш хугацаанд зураг, төсвийг магадлалаар баталгаажуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх шаардлагыг хангасан байх” гэж заасныг зөрчин Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга, дулааны станцын өргөтгөл, Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамжийн багц-1, багц-2, цэцэрлэг, Соёлын төвийн барилга гэсэн 45,306.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ-ний зураг, төсвийн магадлалын дүгнэлт гарахаас өмнөх хугацаанд тендер зарласан байна.

Аудитын хамрах хугацаанд хэрэгжүүлсэн ТАХ-ний төсвийн магадалсан дүн, Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөг, тендер зарласан үнэ, гэрээний дүнг харьцуулж үзвэл дараах байдалтай байна. /Хүснэгт№4/

ТАХ-ний зураг, төсөвт магадлалын дүгнэлт гаргуулсан судалгаа

/сая төгрөг/

Д/д	УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний нэр	Магадалсан төсвийн дүн	Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөг	ТАХ-ний төсөвт өртөг /тендер зарласан/	Гэрээний дүн
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга /Дорноговь, Сайншанд сум/	29,044.37	25,101.60	25,101.6	25,101.60
2	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорноговь, Сайншанд сум/	3,448.28	3,321.20	3,321.2	3,158.74
3	Сумын төвийн авто замын шинэчлэл, 2.15 км /Дорноговь, Замын-Үүд сум/	5,569.91	4,755.70	4,755.7	4,755.70
4	Саран хөхөө театрын барилга, 700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/	16,806.05	18,503.10		18,503.08
5	Соёлын төвийн барилга /Дорноговь, Дэлгэрэх сум/	4,736.08	4,191.90	4,191.9	4,148.10

6	Ундны усны 3000 м3 багтаамжтай усан сан /Дорноговь, Замын-Үүд сум/	1,999.76	2,000.00	2,000.0	1,996.85
7	Дорноговь аймгийн дулааны станцын өргөтгөл /Дорноговь, Сайншанд сум/	5,999.78	5,999.80	5,999.8	5,991.44
8	Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Дорноговь, Сайншанд сум/ Багц 1	508.00	508.00	821.9	467.03
9	Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Дорноговь, Сайншанд сум/ Багц 2	313.90	313.90		306.76
ДҮН		68,112.23	64,695.20		64,429.31

Төсөвт өртгийг магадлалаар баталгаажсан төсвийн дүнд үндэслэхгүйгээр төлөвлөн, баталж хэрэгжүүлснээр гэрээний дүнд өөрчлөлт оруулах, нэмэлт гэрээ байгуулж үнийн зөрүү олгох, ажил дутуу хийгдэхэд нөлөөлсөн байна.

Зураг, төсвийн магадлалын дүгнэлт гарахаас өмнө хугацаанд тендер зарлаж, худалдан авах ажиллагаа зохион байгуулсан зөрчилд өмнөх аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт бүрэн хангадаагүй байх тул холбогдох журмын дагуу албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2.3. Зарим төсөл арга хэмжээг холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт заасан шалгуурын дагуу үнэлээгүйгээс 4 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт цуцлагдсан байна.

УТХО-аар эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарласнаас 3 ТАХ-ний худалдан авах ажиллагаа оролцогчгүй, ТББ шаардлага хангаагүй, оролцогчоос гомдол гаргасан зэрэг шалтгаанаар хүчингүй болж, нэг ажлын тендерийг 34 удаа зарласан байна.

3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь хүлээн авсан хэдий ч зарим ажил зураг, төсвийн дагуу хийгдээгүй, ашиглагч байгууллагын НББ-д бүртгээгүй байна.

3.1. Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих ТАХ-ний санхүүжих дүнг Төсвийн тухай хуульд бүрэн тусгасан ч, үнийн өсөлтийн зөрүүний нэмэлт санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгаж баталсан байна.

Аудитын хамрах хугацаанд хэрэгжсэн 12 ТАХ-ний санхүүжилтэд 26,603.5 сая төгрөгийг олгохоор баталж, 30,359.3 сая төгрөгийг олгож, үүнээс 11,989.9 сая төгрөгийг аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулан, ТАХ-ний гүйцэтгэлийг үндэслэн 18,270.3 сая төгрөгийг олгосон байна.

УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний зардалд орон нутгийн төсвөөс 2022 онд 8,177.1 сая төгрөг, 2023 онд 3,755.0 сая төгрөг, нийт 11,932.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 2022 онд орон нутгийн төсвөөс олгосон 1,047.2 сая төгрөгийг 2023 оны Төсвийн тухай хуулиар баталж, орон нутгийн төсөвт нөхөн олгож, 2024 онд 450.0 сая төгрөгийг олгосон байна.

Замын-Үүд сумын төвийн 2.15 км автозамын шинэчлэлийн 4,755.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-д 2024 онд 1,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан хэдий ч тус ТАХ-г гүйцэтгэгч компани ажил гүйцэтгэх гэрээний хугацаанаас нь өмнө дуусган, ашиглалтад хүлээлгэн өгч, 4,755.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна. /Хүснэгт №6/

УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний эх үүсвэр, тайлант оны гүйцэтгэл

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Гэрээний дүн	Төсөвт өртөг	Тайлант онд санхүүжих	Аймгийн ТЕЗ-д олгосон	Үүнээс барьцаа дансанд байршуулсан	Тайлант оны гүйцэтгэл
		Эхлэх	Дуусах						
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга /Дорноговь, Сайншанд сум/	2024	2025	25,101.6	25,101.6	7,530.5	7,530.5	7,530.5	-

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

2	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорноговь, Сайншанд сум/	2024	2025	3,158.7	3,321.2	1,660.6	1,660.6	-	1,660.6
3	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын автобус /Дорноговь, Сайншанд, Замын-Үүд сум/	2024	2024	962.0	1,000.0	1,000.0	1,000.0	-	962.0
4	Сумын төвийн авто замын шинэчлэл, 2.15 км /Дорноговь, Замын-Үүд сум/	2024	2025	4,755.7	4,755.7	1,000.0	4,755.7	-	4,755.7
5	Саран хөхөө театрын барилга, 700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/	2021	2024	18,503.1	18,503.1	7,033.8	7,033.8	2,637.6	4,396.2
6	Соёлын төвийн барилга /Дорноговь, Дэлгэрэх сум/	2024	2025	4,148.1	4,191.9	1,257.6	1,257.6	-	1,257.6
7	Ундны усны 3000 м3 багтаамжтай усан сан /Дорноговь, Замын-Үүд сум/	2024	2025	1,996.8	2,000.0	1,000.0	1,000.0	-	1,000.0
8	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Дорноговь/	2024	2025	1,797.7	1,800.0	1,800.0	1,800.0	1,797.7	-
9	Дорноговь аймгийн дулааны станцын өргөтгөл /Дорноговь, Сайншанд сум/	2024	2025	5,991.4	5,999.8	2,999.9	2,999.9	-	2,999.9
10	Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Дорноговь, Сайншанд сум/ Багц 1	2024	2024	467.0	508.0	508.0	508.0	-	467.0
11	Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Дорноговь, Сайншанд сум/ Багц 2	2024	2024	306.8	313.9	313.9	313.9	24.1	282.7
12	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Дорноговь, Замын-Үүд сум/	2024	2024	488.6	499.3	499.3	499.3	-	488.6
Нийт дүн				67,677.5	67,994.5	26,603.6	30,359.3	11,989.9	18,270.3

Засгийн газрын 2024 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 249 дүгээр тогтоолын дагуу УТХО-аар 2024 онд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан боловч, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл үүссэн 4 ТАХ-ны 11,989.9 сая төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

УТХО-аар эрх шилжиж өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж байгаа 18,503.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Саран хөхөө театрын барилгын ажлын санхүүжилтэд өмнөх онд 10,248.4 сая төгрөг, 2024 онд 4,388.2 сая төгрөгийг, нийт улсын төсвөөс 14,636.6 сая төгрөгийг олгосон.

Мөн орон нутгийн төсвөөс нийт 2,450.0 сая төгрөг санхүүжүүлснээс өмнө онд 2,000.0 сая төгрөг, 2024 онд 450.0 сая төгрөгийг олгосон байна. /Хүснэгт№7/

УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-д олгосон санхүүжилт

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээ	Тоо	Олгосон санхүүжилт		
			Өмнөх онд олгосон	Тайлант онд гүйцэтгэгчид олгосон	Нийт олгосон
1	Шинэ хөрөнгө оруулалт	11	-	13,874.10	13,874.10
2	Шилжих хөрөнгө оруулалт	1	10,248.40	4,388.20	14,636.60
Дүн		12	10,248.40	18,262.30	28,510.70

Аудитад хамрагдах хугацаанд он дамжин хэрэгжих болон бүрэн хэрэгжиж дуусаагүй 7 ТАХ-ний гүйцэтгэлийн явцыг үзэхэд дараах байдалтай байна. /Хүснэгт№8/

ТАХ-ний гүйцэтгэлийн харьцуулалт /2024.12 сар/

/хувиар/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний хугацаа	Захиалагчийн хяналтаар	Ажлын гүйцэтгэлийн хувь
---	---------------------------	------------------	------------------------	-------------------------

			гүйцэтгэл /хувь/	
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга /Дорноговь, Сайншанд сум/	2024.12.31 2026.06.30	0	0
2	Саран хөхөө театрын барилга, 700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/	2021.06.15 2024.05.01	62.06	83.04 /11.15/
3	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Дорноговь/	2024.11.11 2025.08.13	0	0
4	Ундны усны 3000 м3 багтаамжтай усан сан /Дорноговь, Замын-Үүд сум/	2024.07.15 2025.03.31	97.0	50.08 /10.22/
5	Дорноговь аймгийн дулааны станцын өргөтгөл /Дорноговь, Сайншанд сум/	2024.09.18 2025.10.10		50.07
6	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорноговь, Сайншанд сум/	2024.06.21 2025.07.01	50.0	52.57 /09.30/
7	Соёлын төвийн барилга /Дорноговь, Дэлгэрэх сум/	2024.09.18 2026.10.30	30.0	30.32 /11.21/

3.2. УТХО-аар хэрэгжүүлсэн 5 ТАХ-ний гэрээг холбогдох хууль, журмын шаардлагад үндэслэхгүйгээр сунгасан байна.

УТХО-аар Дорноговь аймагт 2024 онд өмнөх оноос шилжиж ирсэн 1, дараа онд дамжин хэрэгжих 7, 2024 онд хэрэгжиж дуусах 4, нийт 12 ТАХ-г хэрэгжүүлж, 5 ТАХ-г бүрэн хэрэгжүүлж дуусган ашиглалтад хүлээж авсан, үүнээс тус онд хэрэгжиж дуусах 4, өмнөх оноос шилжин хэрэгжсэн 1, нийт 5 гэрээг гүйцэтгэгч компаниас ирүүлсэн хүсэлтийн шалтгаан нөхцөлийг холбогдох хууль, журамд заасан шалгуурыг үнэлэхгүйгээр шийдвэрлэж, сунгасан байна.

3.3. Зураг, төсвийн дагуу хийгдээгүй, бүрэн хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.

Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэмд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэхээр заасан боловч зөвлөмж бүрэн биелэгдсэн байдалд хяналт тавихгүй, бүрэн хийгдээгүй ажлыг ашиглалтад хүлээн авсан байна. Үүнд:

- Замын-Үүд сумын хуучин 80 м³ усан сан байгуулах ажлыг 2025.02.16-ны өдөр ашиглалтад оруулсан боловч ус халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийг байрлуулж ашиглалтад оруулаагүй байна.
- Саран хөхөө театрын барилгын ажлын тайз технологи, интерьерийн зурагт өөрчлөлт оруулах тухай Соёлын яамнаас шийдвэрлэсний дагуу 2024.05.29-ний өдөр ажлын даалгавар боловсруулж, зураг, төсөв боловсруулах санхүүжилтийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэх тухай албан бичиг ирүүлсэн байна.
- Замын-Үүд сумын төвийн 2.15 км авто замын шинэчлэл хийх ажлыг 2025.08.25-ны өдөр дуусахаар гэрээг байгуулсан хэдий ч явган хүний замын ажлыг хийгээгүй байхад 2024.11.11-ний өдөр авто замыг ашиглалтад хүлээн авсан байна.

Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэмд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэхээр заасны дагуу дээрх чанаргүй хийгдсэн ажлыг барилгын норм дүрэм, стандартын дагуу гүйцэтгүүлж зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д “Аймгийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавина” гэж заасан.

УТХО-аар хэрэгжүүлсэн 10 ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ, Эрчим хүчний үндэсний төв хэрэгжүүлэн, 6 ТАХ-ний хяналтын зардалд нийт 281.5 сая төгрөгийг олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга ГХБХБГ-тай захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, тус албаны 1 мэргэжилтэн, гэрээт 3 инженер, нийт 4 ажилтан УТХО, ОНТХО, ОНХС, бусад эх үүсвэрээр орон нутагт хийгдсэн 61 ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд ажиллах хүчний тоо, хяналт тавих ажлын тоо харьцангуй, хяналт хэрэгжүүлэх ТАХ-ний байршил алслагдсан зэрэг нөхцөл байдал нь захиалагчийн хяналтыг чанартай хэрэгжүүлэхэд нөлөөлсөн байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажилд зураг, төсөв зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1-т “Зураг, төсөв зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина” гэж заасан.

УТХО-аар хэрэгжүүлсэн 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд зохиогчийн хяналт хэрэгжүүлэх гэрээ байгуулж, 7 ТАХ-ний хяналтын зардалд 98.6 сая төгрөгийг олгосон ба зураг, төсөв зохиогчид Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдагаас зарим тохиолдолд үе шатны хяналтыг тухай бүр хийхгүй, ил, далд ажлын актыг бодит байдалд үндэслэж баталгаажуулахгүй байх, ашиглалтад хүлээж авах комисст дүгнэлт гаргаж санхүүжилт авах нөхцөл үүсэж, ТАХ-г хэрэгжүүлэгч компани үе шатны ажлыг зураг, төсвийн дагуу чанартай хийхгүй байх эрсдэл үүсэхээр байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт шалгалт хийгээгүй, дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

УТХО-аар өмнө болон аудитад хамрагдах хугацаанд хэрэгжүүлсэн зарим бүрэн хэрэгжээгүй ТАХ-г улсын комиссоор хүлээн авч, ашиглалтад оруулснаар зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгч компаниуд чанаргүй гүйцэтгэсэн ажлыг хуульд заасны дагуу засварлах үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй орхиж байгаагаас хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Орон нутгийн мэргэжлийн байгууллагуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөндөө хөрөнгө оруулалтын ажилд хяналт тавих ажлыг тусгаж хэрэгжүүлээгүй байгаа нь УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чанар, үр дүнд нөлөөлсөн байна.

3.4. Бүрэн хэрэгжиж дууссан 7,491.5 сая төгрөгийн өртөгтэй, 4 ТАХ-г ашиглагч байгууллагын НББ-д тусгаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 8,577.6 сая төгрөгийн өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дуусган комисс хүлээн авсан боловч 7,491.5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын автобус /Сайншанд, Замын-Үүд сум/ - 962.0 сая төгрөг,
- Сумын төвийн авто замын шинэчлэл 2.15 км, /Замын-Үүд сум/ - 4,755.7 сая төгрөг,
- Ундны усны 3000м3 багтаамжтай усан сан /Замын-Үүд сум/ - 1,000.0 сая төгрөг.
- Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Сайншанд сум - Багц 1, Багц 2 - 773.8 сая төгрөг.

УТХО-аар бүрэн хэрэгжүүлж дууссан 5 ТАХ-ний ашиглалтын байдлыг авч үзэхэд Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж нийлүүлэх, Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийн цахилгаан хангамж багц-1, багц-2, Замын-Үүд сумын төвийн 2.15 км авто замын шинэчлэлийн ажлууд тухайн сумын иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, тухтай орчныг бүрдүүлсэн байна.

Сайншанд, Замын-үүд сумын ЕБС-ийн сурагчдын хэрэгцээнд автобус худалдан авах, 192.4 сая төгрөгийн өртөгтэй 5 ширхэг автобусыг аймгийн ОНӨА хүлээн авч, “Говь консалтинг менежмент” ОНӨҮГ-т хүлээлгэн өгсөн боловч тус газар нь НББ-д бүртгээгүй, одоогоор ашиглалтгүй байна.

УТХО-аар хэрэгжүүлж ашиглалтад оруулсан ТАХ-г ашиглагч байгууллага өнөөдрийг хүртэл данс бүртгэлд тусгаагүй, захиалагч байгууллагаас ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах үүргээ хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, ашиглалт, хамгаалалтын асуудал орхигдохоор байх тул хөрөнгийг бүртгэлд тусгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- УТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төсөвт өртгийг дэлгэрэнгүй тооцоолоогүй, ТАХ-г үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг журам, аргачлалын дагуу хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн зорилт бүрэн хангагдахгүй байна.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн зарчмыг баримтлахгүй ТЕЗ-ийн төсвийн төсөл хүргүүлснээс хойш хугацаанд зураг, төсөв хийсэн 7, магадлалын дүгнэлт гаргуулсан 8, техникийн нөхцөл олгосон 4 ТАХ-г төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлсэн байгаа нь ТАХ-г хэрэгжүүлэх явцад ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орох, төсөвт өртөг болон төсвийн ачааллыг нэмэгдүүлэх нөхцөл үүсэж байна.
- Аудитад хамрагдах хугацаанд 45,306.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ-ний зураг, төсвийг тендер зарлагдсанаас хойш хугацаанд магадлалаар баталгаажуулсан байна.
- Худалдан авах ажиллагааны газар нь 12 ТАХ-ны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зохион байгуулснаас шалгаруулалтад оролцогч 4 аж ахуйн нэгж шалгаруулалттай холбоотой гомдол гаргасныг Сангийн яамнаас хянаж, захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгон, тендер шалгаруулалтыг дахин зарласан байна.
- УТХО-аар эрх шилжиж хэрэгжсэн 5 ТАХ-ний ажил гүйцэтгэх гэрээг гүйцэтгэгч компаниас ирүүлсэн хүсэлтийн шалтгаан нөхцөлийг холбогдох хууль, журамд заасан шалгуурын дагуу үнэлэхгүй шийдвэрлэж, сунгасан байна.
- Орон нутгийн мэргэжлийн байгууллагуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөндөө хөрөнгө оруулалтын ажилд хяналт тавих ажлыг тусгаж хэрэгжүүлэхгүй байгаа нь УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чанар, үр дүнд нөлөөлсөн байна.
- Бүрэн хэрэгжиж дууссан 7,491.5 сая төгрөгийн өртөгтэй, 4 ТАХ-г ашиглагч байгууллагын НББ-д тусгаагүй байна.

Аудитаар нийт 64,787.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчил арилгах тухай 7,491.5 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, зөрчил давтан гаргахгүй байх тухай 4 зөвлөмж хүргүүлсэн.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРАГ О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Сангийн сайдын 295 дугаар тушаалын I, III хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал", IV хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал"-д тусгасны дагуу харьяа байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой санхүү, эдийн засгийн шинжилгээг тодорхой тооцуулах, төсөлтэй холбоотой шийдвэр мэдээллийг системд бүрэн мэдээлэх, иргэдийн санал өгөх байдлыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, цахим системээр төлөвлөх ажлын үр дүнг сайжруулах.
2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 *"Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана"* гэж заасны дагуу төлөвлөлтийн шаардлага хангасан, зураг, төсөвтэй, магадлалын дүгнэлтээр баталгаажсан ТАХ-г хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж төлөвлөх.
3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 *"Төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх"*, Сангийн сайдын 2023 оны А/259 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн зааварчилгаа"-ны 4.1-т *"Гүйцэтгэгч ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал, захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй, захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно"*, 4.4 *"Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно"* гэсэн заалтын шаардлагад нийцүүлэн ажил гүйцэтгэх гэрээг ТАХ-г хэрэгжүүлэх зохистой хугацаанд байгуулах, гэрээний хугацааг сунгаж, хөрөнгө оруулалтын ажлын үр дүн, чанар байдалд үүсэх эрсдэлээс сэргийлэх.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА Ц.САРУУЛЦОГТ ТАНАА:

1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 *"Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална"*, 26.1 *"Захиалагч оролцогчоос ирүүлсэн тендерийг шаардлагад нийцэх эсэхийг энэ зүйлд зааснаар хянан үзнэ"* гэсэн заалтын дагуу тус хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан тендерийн баримт бичгийг үнэлж, гүйцэтгэгчийг шалгаруулах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

№1



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

"Улс төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлантай холбоотой саналгүй болно.


О. БАТЖАРГАЛ

4424111444 19/3022/001-AS

№2



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

"Улсын төсвийн 2024 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"
сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Дээрх тайлантай холбоотой санал байхгүй
болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ОЛЗБАЯР


4425030114

№3


ДОРНОГОВЬ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
403 тст, Нээр төвөр, 1 дүгээр баг,
Сайншана сум, Дорноговь аймаг, 44107
Утас/факс: (976) 7711 1141
Цахим шуудан: dornogovionaga@gmail.com
2025.04.18 № 129
тантай 2025.04.18-ны № 1-6/392 -т

ТӨРИЙН АУДИТЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ
ТАНАА

"Улсын төсвийн 2024 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"
сэдэвт нийцлийн аудит хийгдсэн хяналт шагалтын
тайланд саналгүй болно.

ДАРГА  ДМЭНДБАЯР



443180182

№4



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

"Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Тус аудитын тайлантай холбоотой Дорноговь аймгийн худалдан авах ажиллагааны газар өгсөн зөвлөмж, хуульд заасан үндэслэлийн дагуу өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариулцлагатай байх зарчимд нийцүүлэн ажиллаж байна.

ДАРГА



Ц.САРУУЛЦОГТ